

Хэвлэлийн мэдээ

№ 14-30

2015 оны 2 дугаар сарын 16-ны өдөр

2 дугаар сарын 12-ны өдөр 8 дахь удаагийн Олон улсын Манга шагнал гардуулах ёслол Токио хотод байрлах Японы Гадаад хэргийн яамны “Иикүра” ёслолын ордноо явагдлаа. Энэхүү арга хэмжээг Манга буюу Японы комик урлагийг гадаад орнуудад дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулж буй уран бүтээлчдийг шагнаан урамшуулах зорилгоор Японы Гадаад хэргийн яамнаас зохион байгуулдаг бөгөөд энэ жил 8 дахь удаагаа зохион байгуулагдсан нь энэ юм. Энэ жил дэлхийн 46 улс болон бүс нутгаас нийт 317 уран бүтээлч оролцож, үүнээс Монголын зураач, уран бүтээлч Намбаралын Эрдэнэбаярын “Бумбардай” бүтээл тэргүүн байранд шалгарлаа. Н. Эрдэнэбаяр нь 2004 оноос Манга бүтээж эхэлсэн бөгөөд 2005 онд “300 тайчууд” бүтээл нь түүнийг мэргэжлийн Манга зохиогч болохыг харуулсан юм. Мөн 2011 онд бүтээсэн Эрлэг номун хааны отгон хүүгийн адал явдлыг өгүүлэх “Бонгын адал явдал” нь олон нийтийн зүгээс өндрөөр үнэлэгдсэн билээ. Энэ удаад Олон улсын Манга шагналын тэргүүн байранд шалгарсан “Бумбардай” бүтээл нь одоогоор 9-р цуврал хүртлээ хэвлэгдээд байна.

Японы Элчин сайдын яам

Соёл, мэдээллийн хэлтэс

Утас: 320-777